



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 6/22


Бор-Өндөр сум

Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг
түр орлон гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.2, 43.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ:

1. Засаг даргын Тамгын газрын дарга Зерийновын Ууганжаргал нь ээлжийн амралтаа дутуу эдэлсэн тул 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд ээлжийн амралтаа эдэлж Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Ц.Жаргалсайханаар Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгүүлсүгэй.
2. Засаг даргын Тамгын газрын даргын ажлыг түр орлон гүйцэтгэх хугацаандаа Тамгын газрын даргын төсвийн шууд захирагчаас бусад эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Дотоод ажил хариуцсан ажилтан Ц.Жаргалсайханд үүрэг болгосугай.
3. Засаг даргын Тамгын газрын даргын ажлыг түр орлон гүйцэтгэгч Ц.Жаргалсайханы цалинг одоо олгож буй Дотоод ажил хариуцсан мэргэжилтний цалингаар тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ